

Засагт хан аймгийн Олхонууд гурван хошууны халхчуудын уламжлалт шүтлэг (XIX зууны эцэс XX зууны эхэн үе)

Баасанхүүгийн Батмөнх^{1,*}

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Засагт хан аймгийн “Олхонууд гурван хошуу” хэмээн сурвалж зохиолд тэмдэглэгдсэн Засагт хан аймгийн Эрдэнэ засаг, Баатар засаг, Үйзэн засгийн хошууны халхчуудын уламжлалт шүтлэгийн талаар тоймлон өгүүлэв. Тэдний уламжлалт шүтлэгт байгаль дэлхийг амь даагч эзэн савдагтай хэмээн үзэж гуйн аргадах, далдын ид шидэнд итгэх, дом шившлэг, онгон шүтэх ёс зэрэг эртний шүтлэгийн болон бөөгийн шашны ул мөр багагүй хэмжээгээр уламжлагдан ирсэн байна.

Түлхүүр үг: Засагт хан аймаг, Эрдэнэ засаг, Баатар засаг, Үйзэн засгийн хошуу, уламжлалт шүтлэг

Удиртгал

2020 оны хүн амын тооллогоор Монгол улсад 3 174 565 хүн тоологдсноос 2 659 985 хүн буюу нийт хүн амын 83.79 хувийг халхчууд эзэлж, Монгол угсаатны соёлын цогцолборын гол цөм, мөхлөг нь болсоор байна. Монгол улсад аж төрж буй халхчуудыг дотор нь “Боржигин халх”, “Элжигин халх”, “Хатагин халх”, “Олхонууд халх” гэх зэргээр нэрлэдэг. Тэгээд ч эдгээр халхчуудын түүх, соёл, уламжлалт шүтлэгийг судлан тодруулах нь Монголын түүх, угсаатны судлалд чухал ач холбогдолтой.

“Энэ нэгэн дэвтэр амуй” хэмээх сурвалж зохиолд Засагт хан аймгийн Эрдэнэ засаг, Баатар засаг, Үйзэн засгийн хошуудыг Олхонууд гурван хошуу (Ene nigen, 2006: 29) хэмээн бичсэн бий. Эдгээр халхчууд нь өдгөө Ховд аймгийн Дарви, Чандмань сум, Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдын нутагт бөөнөөр аж төрсөөр байна.

Олхонууд гурван хошууны халхчууд Монгол Алтайн уулархаг нутаг, тал хээр, говь зэрэг байгаль цаг уурын хувьд харилцан адилгүй бүс нутагт аж төрсөөр ирэв. Иймд байгаль цаг уурын дээрх хүчин зүйлээс хамаарч Олхонууд гурван хошууны халхчуудын соёл, шашин шүтлэгт зарим өвөрмөц онцлог бий.

Гэвч эдүгээ Олхонууд хошуудын халхчуудын түүх, соёл, уламжлалт шашин шүтлэгийг судлан шинжилсэн зүйл хомс байна. Иймд эл өгүүлэлд баруун халхчуудын нэгэн хэсэг болох Засагт хан аймгийн Олхонууд гурван хошууны халхчуудын уламжлалт шүтлэгийг хөндөн судалж, нэгтгэн бичихийг оролдлоо.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Бид сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Ховд аймгийн Дарви, Чандмань сум, Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдын нутагт угсаатны судлалын судалгаа хийж, халхчуудын түүх, соёлыг нэхэн судалсаар ирэв. Судалгааг дараах маршрутын дагуу хийлээ.

1.2011, 2015, 2017-2021 онуудад Ховд аймгийн Дарви, Чандмань сумд

2.2014, 2018, 2021 онуудад Говь-Алтай аймгийн Хөхморьт сум

3.2021 онд Баян-Уул, Жаргалан сумдын нутагт тус тус ажилласан болно.

Энэ явцад Олхонууд гурван хошууны халхчуудын уламжлалт шүтлэгийн талаар баримт хэрэглэгдэхүүн цуглуулж, судалгааны баримт, мэдээ, санал, дүгнэлттэй харьцуулан, учир шалтгаан, мөн чанарыг тодруулахыг зорилоо.

Хэлэлцүүлэг

Засагт хан аймгийн Олхонууд гурван хошууны халхчууд эрт цагаас байгаль дэлхий, уул хайрханаа тахиж шүтсээр иржээ. Тэдний тахин шүтэж ирсэн уул хайрхдын нэг нь Сутай хайрхан юм. Сутай хайрхан нь д.т.д 4090 метрийн өндөрт оршдог Засагт хан аймгийн хамгийн өндөр уул хайрхан юм (Зураг 1).

Эрдэнэ засгийн хошууны ардууд Монгол орны өрнө зүгийг дааж сахисан харуул хайрхан-Сутай уулын эзэн тэнгэр нь “сэргэр хоёр эврээ дээд тэнгэр өөд цоролзуулж, урд хоёр туурайгаараа газрын хөрс онгичиж, нүдээ улаанаар эргэлдүүлсэн сүрлэг догшин сарлагийн бух хөлөглөсөн, цайвар цагаан нигууртай, намуун дөлгөөн харцтай, зүүн мутартаа эрдэнийн таваг, баруун мутартаа шар торгон хадаг намируулсан, улаан өмсгөлтэй залуу бүсгүй байдаг” гэж өгүүлнэ.

¹ МУИС-ийн Баруун бүсийн сургууль

* Холбоо барих зохиогч: batmunkhbaasankhuu09@gmail.com

Сутай хайрханы сангийн сударт:

Онц догшин газрыг ухах малтах уул хайрханыг товроглох

Онгон модыг огтолж, догшин усыг хутган булингартуулахыг

Ойшоож эс мэдсэний эрхээр үйлдснээ тэнгэр лус шивдагуудад хандаж

Онцгой хор хүргэх, хорлол харшлалыг арилгахыг өгүүлэгтүн

Буянт хүмүүний нас сүүдэр, мал сүргийн гарз

Бусар шарнууд, чононцор тэргүүтэн араатны хорлол

Буруу хэрүүл тэмцэл эвдрэл самуурал цаг бусын бороо

Бусад үл хүсэхүй муу шалтгаан нөхцөл бүхнийг амирлуулж хайрла

Энэ хүн зоны насан уртсаж эд таваарын язгуур үндэс арвижиг

Эсрэг тэсрэг сэтгэлд зохилдсон богдсын номд орж

Эрдэнэт мал сүрэг үржин арвидаад үл хорогдон

Эрхин сайн буяны үрийг сав шимийн ертөнцөд арвитгаж хайрла хэмээн бичжээ.

Эрдэнэ засгийн хошууныхан Сутай хайрханы Ноёны хүрэн уулыг эрт цагаас тахиж шүтсээр ирэв. Уулын оройд эрт цагаас хошууны засаг ноёд наадам хийдэг байжээ. Үүнээс улбаалан уулын нэрийг хошууны ардууд “Ноёны хүрэн өндөр” хэмээн нэрийдэх болов. Ноёны хүрэн өндөрт эмэгтэй хүн гардаггүй бөгөөд хэрвээ гарвал лус савдаг догширно гэж үздэг. Оройн хэсэг жинхэнэ өндөр уулын таг, нугын үзэсгэлэнт сайхан байгальтай (Сутайн 2008: 14).

Жаргалант хайрханыг нутгийн ардууд ширээ бөхтэй атан тэмээний дүртэй уул хэмээдэг. Бумбат хайрханыг эрт цагт шинжээд үр жил шим сайтай өгөөж хишиг ихтэй эх амьтны шинж агуулсан нутаг учир эм савдагтай гэнэ (Зураг 2). Тэгээд үр ач нараа олшруулж өгөөж хишгээ арвитгахыг нь тэтгэж шижирил алтан бумбанд есөн эрдэнийг хийж шүншиглээд ариун хэвлийд нь оршоон онголж, бумбаныхаа хишгийг буман үедээ хүртээж байхыг шившин ерөөж Бумбат хайрхан нэр хайрласан гэдэг домогтой (Дандар 2008: 13).

Баатар засгийн хошууныхан эрт цагаас Баянбогд хайрхан (өдгөө Говь-Алтай аймгийн Баян уул сумын нутагт оршдог)-ыг шүтэж, цай сүүнийхээ дээжийг өргөсөөр ирэв. Баянбогд хайрханы эзэн савдаг нь цагаан морь унасан эр хүн гэж ярьдаг. Иймд Баянбогд хайрханыг хурдан морины шүншигтэй уул гэдэг (Зураг 3).

Газар ус шүтэх хамгийн өргөн дэлгэр тархсан хэлбэр нь овоо тахилга юм. Овоог томоохон уул, даваа, гол ус, нуурын дэргэд босгодог. Овоог зуны эхэн сард багтаж тахина. Овоо тахихдаа бүтэн

хониор тахил өргөж, дүүрэн идээ будаа засч, айл бүр ааруул, хурууд, өрөм, бяслаг, цай сүүний дээжээ авч очиж овоондоо өргөж, тэнгэр бурхандаа даатгаж, лус савдагаа баясгана.

Эрдэнэ засгийн хошууны ардууд Булган тохой, Овоон дэн, Тахилт, Хишигтийн овоо, Цүнхэл, Шар хамарын овоодыг тахисаар иржээ. Бумбат хайрханы Цүнхэлийн овоог тахисны дараа Шар хамарын овоог тахидаг¹.

Баатар засгийн хошууныхан Баянхайрхан уул, Чандманьхайрхан уулыг тахина. Баян, Наран, Бор хайрхан, Их гол, Нам, Тахилт, Чандмань, Өвгөн, Хүйсийн говийн Цагаан дэрсний овоо, Жанжин овоо, Халтар даагатын овоог эрт үеэс тахисаар иржээ. Эдгээр овооны заримыг цагаан идээгээр, заримыг шүүсээр тахина. Тухайлбал, Баатар засгийн хошууны Шаравдаржаалин хүрээний лам нар зуны эхэн сард Ловонгийн нурууны овоог тахина. Ловонгийн нурууны өвөрт орших Цагаан хайрханы овоо нь эзэн нь хонь. Цагаан идээгээр тахьдаг. Уулын хэлбэрийг жанч нөмөрсөн лам, ном айлдаж буй дүртэй гэж ярьдаг байна (Гомбосүрэн 2019: 472).

Хүйсийн говийн Бор хайрханы овоог цагаан идээгээр тахидаг бол, Цагаан дэрсний овоог хонины бүтэн ууцаар тахина. Луст нь сүүлгүй могой байдаг аж². Намын давааны овооны эзэн савдаг нь буга бөгөөд цагаан идээгээр тахина (Зураг 4).

Чандмань хайрханд өвгөн овоо, хүүхдийн овоо гэж хоёр овоо буй. Энэ хоёр овоог заавал нэг өдөр зэрэг тахидаг³. Сангийн далай буган, Нуур могой луу савдагтай аж.

Дөргөн нуурын хөвөөнд орших Жанжин овооны талаар нутгийн ардуудын дунд нэгэн домог ам дамжин уламжлан иржээ. Үүнийг өгүүлбээс: “Эрт урьд цагт энэ нуурын хавийн газар нутаг догшроод, хэдэн жилээр мал хуй нь барагдаж, өвс ургамал гандаад хүн малгүй хэцүүджээ. Нэг зун нутаг усаа аргадан наадам хийх болов. Гэтэл нэг мэргэн хүн хэлжээ. Энэ наадамд жаахан охин унасан шарга морь хол тасархай түрүүлж ирнэ. Тэр бол хүн биш, тиймээс барьж авч үгүй хийвээс ард олон, ахуй мал амаржина гэжээ. Энэ ёсоор мөнөөх морийг түрүүлж ирэнгүүт хүмүүс барьж аван, охиныг морьтой нь хамт чулуугаар дарж овоо босгосон гэнэ. Үнэхээр тэр хүүхдийн эцэг, эх,

¹ *Ховд аймгийн Чандмань сумын уугуул Дамдиндоржийн Цэвээнравдан (1968 онд төрсөн, бич жилтэй, эрэгтэй, Халх, Цэцэгт Олхонууд овог, Талын булаг баг) гуайгаас тэмдэглэж авав.*

² *Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын уугуул Тожилын Ганбаатар (1967 онд төрсөн, морь жилтэй, эрэгтэй, Халх, Тугчин овог, Хүйсийн говь баг) гуайгаас 2021 онд тэмдэглэж авав.*

³ *Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын уугуул Дүгэрийн Гомбосүрэн (1935 онд төрсөн, гахай жилтэй, эрэгтэй, Халх, Мухар овог, Хүйсийн говь баг, Монгол улсын Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, анагаах ухааны доктор) гуайгаас 2021 онд тэмдэглэж авав.*

морины эзэн гэж гарч ирээгүй аж. Удалгүй нутаг оронд ургамал ногоо ургаж, хүн зоны сэтгэл тэнийж амар амгалан болжээ”⁴.

Жанжин овоог хөх саарал өнгийн чулуугаар үйлджээ. Гол том овоог тойруулаад 12 жижиг овоо босгосон байна. Овооны урд хэсэгт бас хоёр жижиг овоо босгожээ. Жанжин овоо нь эдүгээ Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын нутагт х.ө 47 34 45.5, з.у 093 31 26.5 -ын солбилцолд д.т.д 1129 метрийн өндөрт оршино.

Үйзэн засгийн хошууны ардууд Бүрэнхайрхан уулыг тахина. Хүрээний лам нар зуны эхэн сард Хасагт хайрханы Батбуянтын овоог тахина. Түүнээс гадна Тахилт манханы овоог тахидаг.

Халхчууд овоо таарвал мориноосоо бууж овоонд чулуу өргөнө. Ингэхдээ:

Овооны эх нь танд

Олзны эх нь маньд гэж ерөөдөг.

Монголчуудын дунд хүрээлэн буй юмс үзэгдэл цаанаа амь даагч эзэн, сүнс сүлдтэй гэх ойлголт нэлээд бий. Үүнийг “амьдчилахуй ёс” буюу “анимизм” гэдэг. Олхонууд хошуудын халхчууд бас мод, ургамлыг эрт үеэс шүтсээр иржээ. Өнчин хайлаас мод тэргүүтнийг огтлохыг ихэд цээрлэнэ. Мод, ургамлыг далдын ид шидтэйд тооцдог.

Баруун халхчууд тахилгат уул усны орчимд бусдаас содон ургасан мод, онцгойрч ургасан хэсэг модонд гар хүрч хөндөхийг цээрлэнэ. Бас элдэв ургамал таслахыг цээрлэн, ямар нэгэн золгүй явдлын учир шалтгааныг цээр хориотой ургамалтай холбон ойлгодог байжээ. Вансэмбэрүү цэцгийг “тэнгэрийн цэцэг” гэдэг. Вансэмбэрүү өндөр уулын хад асганд хосоороо ургадаг. Вансэмбэрүү ургасан газарт гэр, майхан бариад лусыг аргадаж, идээ, цацал өргөж, тэнгэрт үзүүлэлгүй авдаг ёс байжээ.

Эрдэнэ засгийн хошууны ардууд Бумбат хайрханы сав дахь Усан хөлийн хөндийгөөс яргай мод авахыг ихэд цээрлэдэг байв. Учир нь догшин газрын ховор мод авбал лус савдаг догширно хэмээн сүсэглэнэ. Тэндээс ганц нэг хүн л яргай авдаг байсан гэдэг⁵. Үйзэн засгийн хошууны нутаг Жаргалан ууланд яргай бага сага ургана. Хүмүүс тэр бүр авдаггүй.

Халхчууд арцыг “ариун мод” гэж ихэд хүндэтгэж, үндсээр нь ихэвчлэн айраг, сүү хутгах халбага, цацал, морины хусуур хийдэг. Булаг усанд хог буртаг хийх, сүү дусаах, малын цус нөж оруулахыг ихэд цээрлэнэ. Мал ихэрлэвэл бэлгэшээдэг. Гэвч адуу ихэрлэхийг тэр

бүр ташаадаггүй. Ихэр унагыг хөлгүй усанд шахаж, амьд гарч ирвэл өсгөдөг байна.

Гурван хошууны халхчуудын дунд амьтны тухайт шүтлэг, зан үйл нэлээд бий. Анд явж байх үед туулай таарвал бэлгэшээнэ. Ангийн түрүү “бор халзан туулай” гэж ярьдаг. Ойрад монголчууд ч ан авд явах үед туулай таарахыг ихэд бэлгэшээнэ. Харин Халхчууд үнэг таарвал таашаадаггүй. Энэ зан үйл Монголчуудын дунд нийтлэг байсан бололтой юм.

Ангийн олзлыг олуулаа хувааж иднэ. Ан агнасны дараа ганзаганы хувь буюу шорлого тараана. Ганзаганаасаа хэтэрсэн болон сүргийн магнай ан агнахыг цээрлэдэг. Бас олон гөрөөс дотор ганц эр гөрөөс байвал агнадаггүй. Сүргийн өсөлт, тоо толгойд сөргөөр нөлөөлнө гэж үздэг.

Олон үнэг агнахыг цээрлэнэ. Хэрэв олныг албал даруулга болгож нэг чоно алдаг байсан гэдэг. Чонын нэрийг хэлдэггүй, “боохой”, “мөлхөө”, “их амт”, “саарал” гэхчлэн зөрүүлэн нэрлэнэ. Ирвэсийг нутгийнхан “цоохор гайхал”, “цоохор” гэхчлэн нэрлэнэ.

Анчин ан агнаад зүлдээ заавал өөрөө авна. Гахай агнасан анчин толгойг нь авдаг. Янгир агнасан анчин зүлдээс гадна өвчүүг нь, бас шархтай махаа авна⁶. Энэ нь ангийн аз харина гэж үзэхээс гадна ан агнасны баталгаа байсан бололтой.

Олхонууд гурван хошууны нутагт байгалийн өвөрмөц тогтоцтой газрууд бий. Тухайлбал Сутай хайрханы Хөшөөтийн Цахир боомд байгалийн тогтоцоороо янгирын дүрс бий. Үүнийг нутгийнхан их учиртай гэж ярих юм. Учир нь Хөшөөт бол эрт үеэс янгирын тархалтын гол нутаг юм. Бас Майхан цахир хэмээх майхан хэлбэртэй уул бий. Үйзэн засгийн хошууны нутаг Жаргалан хайрханд янгирын хэлбэр дүрстэй хад байдаг аж.

Чоно мал сүрэг рүү орох, мал идэхийг гай гарз хэмээн үздэггүй, чонын ам өөдрөг, мал сүрэг өснө хэмээн бэлгэшээдэг. Харин мал сүрэгт хулгай орвол хулгайн бузар, хулгайн хар гар хэмээн ихэд цээрлэдэг. Хүүхэд тогтдоггүй айл хүүхдийн хүйг чонын шөрмөсөөр боох, чонын арьсанд боож авах зэрэг зан үйлүүд байсан аж. Түүнээс гадна Шаалуу, Бэлтрэг гэх нэр өгвөл осолддоггүй хэмээн үздэг. Онго шүтээн буюу тотем амьтныхаа нэрээр овгоо нэрлэх явдал ч монголчуудын дунд байжээ. Эрдэнэ засгийн хошууны халхчуудын дунд тэмдэглэгдсэн чинос овог ч үүний тодорхой жишээ юм. Тэд чоно онгонтой байсан учраас ийм нэр зүүсэн бололтой (Очир 2012: 290).

Олхонууд гурван хошууны халхчуудын дунд дом шившлэгийн ёс (смаги) тодорхой хэмжээгээр уламжлагдан иржээ. Энэ ёс нь шившлэг үг, домнох

⁴ Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын уугуул Гүндсамбуугийн Даржаа (1961 онд төрсөн, үхэр жилтэй эрэгтэй, Халх, Батнаа овог, Сангийн далай баг) гуайгаас 2021 онд тэмдэглэж авав.

⁵ Ховд аймгийн Чандмань сумын уугуул, аймгийн аварга малчин Мягмарын Гүрбазар (1947 онд төрсөн, гахай жилтэй, эрэгтэй, Халх, Олхонууд овог, Талын булаг баг) гуайгаас 2020 оны 4 дүгээр сард тэмдэглэж авав.

⁶ Говь-Алтай аймгийн Жаргалан сумын уугуул Пүрэвийн Сүрэнжав (1952 онд төрсөн, луу жилтэй, эрэгтэй, Халх, Ениээбүү овог, Бүрэн баг) гуайгаас 2021 онд тэмдэглэж авав.

зан үйл зэргээс бүрдэнэ. Халхчуудын дунд нар, сар хиртвэл цагаан ястай хүн чанга хашгирч, дуу чимээ гаргадаг зан үйл хожим хүртэл байжээ.

Од харвахад:

Тэнгэрийн од болохоос

Миний од биш

Түй, түй гэж нулимдаг.

Хүүхэд айж цочиж уйлахыг “хөлсөх” гэдэг. Хүүхэд хөлсвөл ширэг хийж домноно. Халуун цог дээр давс цацаж, нар зөв гурав, нар буруу гурав эргүүлж “ум хэрээ бадна дагир базар гарьд хаянгарав хөлү хөлү хумпу” гэж ширэглэнэ⁷. Хүүхэд үнэгчлэх болохтой зэрэг үнэгний дүрс эсгийгээр хайчлаад зүүдэг.

Хүүхдийн ам гэмтвэл нагацын морины амгайгаар домноно. Морийг нь гэрийн гадаа авчраад хазаарыг мулталж, тотгоор оруулж домноно. Морины халуун амгайг аманд нь зуулгаад, “эм дом, эм дом, эм дом” гэж гурван удаа хэлдэг⁸.

Малын дэлэн айх буюу хавдахад гуулин шанагаар зангаж:

Малын толгой өөдөө

Өвчний толгой уруугаа

Эм дом эм дом хэмээн домнодог⁹.

Эрдэнэ засгийн хошуунд хонь мал тасарч хайгаад олдохгүй бүрий болох үед хайчны амыг ноосоор ороогоод униндаа хавчуулна¹⁰. Энэ нь зэрлэг амьтны амыг боож байна гэсэн утгатай юм.

Засагт хан аймгийн Дайчин засгийн хошуунд мал тасраад алга болсон үед авдар дээрээ 7 хоргол тавиад аягаар хөмөрч тавьдаг. Мал олдтол түүнд гар хүрдэггүй. Харин Элжигинчүүд гал мана гэж хэлээд үүдээр харанхуй болохтой зэрэг гал цацдаг байна (Аюуш 2011: 69).

Төв халхад хонины 7 хоргол, галын 7 нүүрс хийж, аягаар хөмөрч тавьж домнодог. Мөн үйлийн хайчны амыг боож ханын өнчин толгой, хатагны хажуу талын унь өлгөдөггүй дээд талын дутуу толгойноос өлгөдөг байна (Аюуш 2011: 7).

Хонины далны ясаар мэргэ тавина. Далыг их зөн, бэлгэдэл, нууцтай гэж ярьцгаадаг. Тухайн айлын хотноос хонь төхөөрч далыг нь шинжиж, айлын генийн сан, буян хишиг, сайн, муу зүйлийг

тодорхойлно. Айлын нууц даланд хадгалагддаг гэнэ лээ. Мэргэ төлөг тавихдаа хонины баруун хааны далаар шинждэг. Далны толгойгоор гэрийн эзнийг шинждэг аж. Засагт хан аймгийн Дайчин засгийн хошууныхан хүзүү нь урт байвал мал барагдана, богино бол сайн гэдэг. Далны толио нь задгай, цагаан бол сайн, захаасаа борлосон бол мал барагдана гэдэг байжээ (Аюуш 2011: 34).

Далыг аргалийн галд шатаана. Галыг ширүүн, эсвэл зөөлөн биш, тохируулж түлнэ. Дал шатаахад мэргэ төөрнө гээд 2-3 хүнээс олон хүн байлгадаггүй. Дал шатах үед час час гэж дуугарвал хэрүүл маргаан, хэл ам ихтэй, тас тас дуугарвал гэр орон, гал бохир гэдэг. Дал шатаагаад гаргаж ирэхэд, олон янзын зураас гардаг. Тэр зураасыг уншиж шинжинэ. Шулуун цуурсан бол ажил саадгүй, хөндлөн цуурсан бол саадтай гэх зэргээр хэлдэг байна¹¹. Шатаасан далаа бурхан шүтээндээ хадгалж болно.

Оросын судлаач Г.Потанин: “...Далаар мэргэлэх арга Монгол даяар тархсан байдаг. Халх, торгууд, урианхай, киргиз нар бүгдээрээ мэднэ. Далыг киргизүүд жаурун, монголоор дал гэдэг ба “далаар мэргэлэх” гэх хэлэхийн оронд “дал тавих” гэж хэлнэ. Мэргэлэх үед далыг морь гэж төсөөлдөг бололтой. Нарийн үзүүр нь цээж хэсэг, өргөн тал нь сүүл хэсэг, голын босоо хэсгийг залаа (киргизээр аргалык), залаагүй талыг киргизээр алакан, монголоор алга, дугуй аяга мэт хонхорхойг киргизээр казан, монголоор хясан буюу тогоо гэнэ. Далыг гал дээр хэсэг хугацаанд байлгасны дараа ан цав үүсэх ба үүгээр нь мэргэлнэ” (Потанин 2018: 85-86) гэж тэмдэглэжээ.

Дүгнэлт

Халх монголчууд эрт цагаас Төв Азийн эрс тэс уур амьсгалтай бүс нутагт аж төрж ирэхдээ байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, хорио цээр, энэрэл хүндэтгэлийн ёс, байгаль хамгаалах сэтгэлгээ, соёлыг буй болгосоор иржээ. Бидний ажигласнаар, Засагт хан аймгийн Олхонууд гурван хошууны халхчуудын уламжлалт сэтгэлгээнд байгаль дэлхийг амь даагч эзэн, савдагтай хэмээн үзэж гуйн аргадах, аз хийморийг урин дуудсан үг хэллэг, хорио цээрүүдэд далдын ид шидэнд итгэх, амьдчилах, дом шившлэг, онгон шүтэх зэрэг эртний шүтлэгийн болон бөөгийн шашны ул мөр багагүй хэмжээгээр уламжлагдан үлдсэн нь судалгааны явцад илрэн мэдэгдэж байна.

⁷ Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын уугуул Туушийн Зэвэг (1938 онд төрсөн, бар жилтэй, эмэгтэй, Халх, Тугчин овог, Хүйсийн говь баг) гуайгаас 2021 онд тэмдэглэж авав.

⁸ Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын уугуул Туушийн Зэвэг (1938 онд төрсөн, бар жилтэй, эмэгтэй, Халх, Тугчин овог, Хүйсийн говь баг) гуайгаас 2021 онд тэмдэглэж авав.

⁹ Ховд аймгийн Чандмань сумын уугуул, нагац эмэг эх Далхаан Бат-Өлзий (1918 онд төрсөн, морь жилтэй, эмэгтэй, Халх, Олхонууд овог, Талын булаг баг)-гөөс 2003 онд тэмдэглэж авав.

¹⁰ Ховд аймгийн Чандмань сумын уугуул, аймгийн сайн малчин Мягмарын Гурбазар (1947 онд төрсөн, гахай жилтэй, эрэгтэй, Халх, Олхонууд овог, Талын булаг баг) гуайгаас 2020 онд тэмдэглэж авав.

¹¹ Ховд аймгийн Чандмань сумын уугуул, нагац ах Жамьяны Загдсүрэн (1941 онд төрсөн, могой жилтэй, эрэгтэй, Халх, Олхонууд овог, Талын булаг баг)-ээс 2003 онд тэмдэглэж авав.

Abstract

Traditional beliefs of khalh people of Olhонууд three hoshuu in Zasagt khan aimag

Baasankhuu Batmunkh

According to historical sources, Erdene zasag, Baatar zasag and Uizen zasag' s hoshuud of Zasagt Khan aimag were written as the three Olhонууд hoshuu in Zasagt Khan aimag. In three hoshuud of Olkhонууд include Darvi and Chandmani of Khovd aimag, Khukhmorit, Bayan-uul and Jargalan sums of Gobi-Altai province.

The research article aims to study the traditional beliefs of Khalkh people of Olhонууд three hoshuu in Zasagt khan aimag. In the traditional thinking of the Khalkh people of the Olkhонууд three hoshuu, traces of ancient worship and shamanism such as animism, smagy, and totemism have been handed down to a large extent.

Keywords: Zasagt khan aimag, Erdene zasag's hoshuu, Baatar zasag' s hoshuu, Uizeng zasag' s hoshuu, traditional beliefs

Ном зүй

Аюуш, Ц. (2011). 1982 онд Төв, Баруун халхад ажилласан угсааны зүйн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн. Монголын угсаатны зүйн хээрийн

судалгааны эх хэрэглэгдэхүүн (1982-1983). Боть VII. Эрхэлсэн С.Чулуун, Хянан нягталж, оршил бичсэн Г.Цэрэнханд, У.Булаг. Эмхэтгэсэн Д.Түвшинзаяа. УБ.

Гомбосүрэн, Д. (2011). Баян-Уулын нэвтэрхий толь. Хянан тохиолдуулсан З.Сэсээр. УБ.

Дандар, Ц. (2008). Бумбат хайрханыхны ургийн сүлжээ. Тэргүүн дэвтэр. УБ.

Очир, А. (2012). Монголчуудын гарал, нэршил. Хоёрдахь хэвлэл. Эрхилэн нийтлүүлсэн Шаравын Чоймаа. УБ.

Потанин, Г.Н. (2018). Монголын баруун хойд нутаг. Эзэн хааны Газарзүйн Нийгэмлэгээс шийдвэрлэсэнээр тус нийгэмлэгийн гишүүн Г.Н.Потанины 1876-1877 онд хийсэн аяллын тайлан ба Монголоос бичсэн захидлууд. II боть Орчуулсан Ч.Баасанжаргал. УБ.

Сутайн. (2008). Сутайн Олхонууд. Хянан тохиолдуулсан Б.Довдонбалжир, Д.Данзан, А.Чогдон, Д.Лхасүрэн. УБ.

Ене nigen (2006). Ene nigen devter amui (энэ нэгэн дэвтэр амуй). Галиглаж хэвлэлд бэлтгэсэн Ж.Гэрэлбадрах. УБ.

Received: March 6, 2024; Revised: Apr 10, 2024; Accepted: Apr 26, 2024



Зураг 1. Сутай хайрхан



Зураг 2. Бумбат хайрхан



Зураг 3. Баянбогд хайрхан



Зураг 4. Намын давааны овоо